



МОНГОЛ УЛСЫН
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

___ оны __ сарын __ өдөр

Дугаар ___

Улаанбаатар

хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, Татварын ерөнхий хуулийн 16 дугаар зүйлийн 16.7 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Татвараас зайлсхийхийн эсрэг ерөнхий дүрмийг хэрэгжүүлэх журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Татварын ерөнхий газар /Б.Заяабал/-т үүрэг болгосугай.

3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар /...../, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга /...../-т даалгасугай.

Ч.ХҮРЭЛБААТАР

ТАТВАРААС ЗАЙЛСХИЙХИЙН ЭСРЭГ ЕРӨНХИЙ ДҮРМИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг.Татвараас зайлсхийхийн эсрэг ерөнхий дүрмийн зорилго

1.1. Энэ журмын зорилго нь татварын схем ашиглан татварын ашиг хүртэж татвараас зайлсхийсэн татвар төлөгчийн үйлдэлд татварын алба нөхөн ногдуулалт хийх, Татварын ерөнхий хуулийн 16 дугаар зүйлд заасан “Татвараас зайлсхийхийн эсрэг ерөнхий дүрэм”-ийг хэрэгжүүлэхэд оршино.

1.2.Татвараас зайлсхийхийн эсрэг ерөнхий дүрэм /цаашид “ерөнхий дүрэм” гэх/-ийг хэрэгжүүлэхдээ олон улсын гэрээ, татварын хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан нийтээр дагаж мөрдөх эрх зүйн баримт бичиг, татварын албанаас баталсан дүрэм, журам, зааврыг мөрдөж ажиллана.

1.3.Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай хэлэлцээр, гэрээг ашиглан ашиг хүртсэн тохиолдолд татвар төлөгчид ерөнхий дүрмийг хэрэглэнэ.

1.4. Ерөнхий дүрмийг Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-д заасан бүх төрлийн албан татварын ногдуулалт төлөлтийн байдалд хяналт тавихад баримтална.

Хоёр. Ерөнхий дүрэм хэрэгжүүлэх нөхцөл

2.1.Татварын ерөнхий хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу дараах нөхцөл зэрэг бүрдсэн тохиолдолд ерөнхий дүрмийг хэрэгжүүлнэ:

2.1.1.дангаараа эсхүл бусад этгээдтэй хамтран татварын схем ашигласан;

2.1.2.татвараас зайлсхийх үйл ажиллагааны үндсэн зорилго нь татварын ашиг хүртэхэд чиглэгдсэн.

2.2.“татварын схем ашиглах” гэж Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.18-д заасны дагуу тодорхойлсон татвараас зайлсхийх зорилго бүхий үйлдэл, гэрээ, зохион байгуулалт, тохиролцоо, амлалт, төлөвлөгөө, төсөл, гүйцэтгэл зэргийг шууд болон шууд бус хэлбэрээр, дангаар эсхүл бусад этгээдтэй хамтран, бүхэлд нь эсхүл хэсэгчлэн хэрэгжүүлсэн үйл ажиллагааг ойлгоно.

2.3. “татварын зайлсхийх үйл ажиллагаа” гэж Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.24-д заасны дагуу тодорхойлсон татварын ашиг хүртэх үндсэн зорилготой дараах нөхцөл, шаардлагын аль нэгийг хангасан татвар төлөгчийн үйлдлийг ойлгоно:

2.3.1.оролцогч талуудын эрх, үүрэг нь бодит нөхцөл байдалд нийцээгүй;

2.3.2.татварын хууль, тогтоомжийг мушгин гуйвуулсан, өөрт ашигтай байдлаар буруу хэрэглэхэд чиглэгдсэн;

2.3.3.бизнесийн зорилго, шаардлага байгаагүй;

2.3.4.бодит бусаар, дүр үзүүлэн хийсэн үйлдэл.

2.4.Татварын ерөнхий хуулийн 16 дугаар зүйлийн 16.6-д заасан татварын схем ашиглан татварын ашиг хүртсэн үндсэн зорилгыг дараах шалгуур үзүүлэлтээр нарийвчлан тогтооно:

2.4.1.татварын схемийг хэрэгжүүлсэн арга, хэлбэр;

2.4.2.татварын схемийн шинж чанар, онцлог, ач холбогдол;

2.4.3. үйл ажиллагааг хэрэгжүүлсэн хугацаа;

2.4.4. татварын схемийг хэрэгжүүлсний үр дүнд хүртсэн татварын ашиг;

2.4.5. татварын схемээс хүлээгдэж байгаа болон хүлээсэн үр дүнгээр тухайн татвар төлөгчийн санхүүгийн байдалд гарсан өөрчлөлт;

2.4.6. татварын схемээс хүлээгдэж байгаа болон хүлээсэн үр дүнгээр үйл ажиллагаанд оролцогч талуудын санхүүгийн байдалд гарсан өөрчлөлт;

2.4.7. татварын схем хэрэгжүүлснээр тухайн татвар төлөгч болон үйл ажиллагаанд оролцогч бусад талуудын эдийн засгийн, бизнесийн хэрэгцээ шаардлага, үр дагавар;

2.4.8. тухайн татвар төлөгч болон үйл ажиллагаанд оролцогч бусад талуудын хэлхээ холбоо.

2.5. Татварын ерөнхий хуулийн 16 дугаар зүйлийн 16.6-д заасан татварын схем ашиглан 16.6.1, 16.6.2, 16.6.3, 16.6.4, 16.6.5-д заасан үр дүнд хүрсэн бол татварын ашиг хүртсэнд тооцно.

2.6. Татвар төлөгчийн татвар төлөхөөс зайлсхийх үйл ажиллагаа нь энэ журмын 2.1-д заасан нөхцөл бүрдсэн бөгөөд мөн журмын 2.2, 2.3, 2.4-т заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан тохиолдолд ерөнхий дүрмийг хэрэглэнэ.

Гурав. Ерөнхий дүрмийг хэрэгжүүлэх

3.1. Татвар төлөгчийн татвараас зайлсхийсэн үйлдэлд тухайн харилцааг нарийвчлан зохицуулсан хуульд заасан арга хэмжээг хэрэгжүүлэн татварыг нөхөн ногдуулах боломжтой бол тухайлсан хууль, тогтоомжийг түрүүлж хэрэглэнэ.

3.2. Татвар төлөгчийн татвараас зайлсхийсэн үйлдэлд энэ журмын 3.1-д заасан тухайлсан хууль, тогтоомжийг хэрэгжүүлэн татварыг нөхөн ногдуулах боломжгүй бол ерөнхий дүрмийг хэрэгжүүлнэ.

3.3. Татвараас зайлсхийх тухайн үйлдэлд ерөнхий дүрэм болон тухайлсан хууль тогтоомжийг давхардуулан хэрэглэхгүй.

3.4. Татварын схемийг татварын ашиг хүртэх үндсэн зорилгогүйгээр тухайн үйл ажиллагааг бизнесийн зайлшгүй хэрэгцээ шаардлагаар хэрэгжүүлсэн бол татварын алба ерөнхий дүрмийг хэрэглэхгүй.

Дөрөв. Татвараас зайлсхийхийн эсрэг авах арга хэмжээ

4.1. Татварын ерөнхий хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-д заасны дагуу татвар төлөгчийн татвараас зайлсхийх үйлдэл нь энэ журмын 2.1, 2.2, 2.3, 2.4-т заасан нөхцөл, шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан тохиолдолд татварын схемийг ашиглаагүй, эсхүл татварын ашиг хүртээгүй байх нөхцөлөөр татварын алба дахин тодорхойлж, татварын ногдолд залруулга хийн, татварыг нөхөн ногдуулна.

4.2. Энэ журмын 4.1-д заасны дагуу залруулга хийн нөхөн ногдуулах татварыг тодорхойлохдоо татварын улсын байцаагч дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.2.1. Татварын схем ашиглан татвараас зайлсхийж татварын ашиг хүртсэнийг татвар төлөгчийн ирүүлсэн баримт материал болон татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн мэдээлэлд үндэслэн энэ журмын 2.1, 2.2, 2.3, 2.4-т заасан нөхцөл, шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан эсэхийг баримтаар нотолно.

4.2.2. Татвар хяналт шалгалт гүйцэтгэж байгаа татварын улсын байцаагч ерөнхий дүрмийг хэрэгжүүлэх эсэхийг шийдвэрлүүлэхийн тулд батлагдсан маягтын дагуу харьяа нэгжийн даргаар баталгаажуулан “Эрсдэлийн удирдлагын хорооны ажиллах журам” -ын 3.1-д заасны дагуу хүсэлт гаргах бөгөөд хүсэлтийг нотлох баримтын хамт Эрсдэлийн удирдлагын хороо /цаашид “хороо” гэх/-нд ирүүлнэ.

4.2.3. Энэ журмын 4.2.2-т заасан нотлох баримтад тухайн татварын төлөгчийн татварын схем ашиглан татвараас зайлсхийж татварын ашиг хүртсэнийг нотлох баримт, танилцуулга, дүгнэлт, татварын ногдолд залруулга хийх тооцоолол болон бусад холбогдох баримт бичиг, судалгаа, мэдээ мэдээллийг хамруулна.

4.2.4.Эрсдэлийн удирдлагын хорооны ажиллах журмын 3.4-т заасны дагуу хүсэлтийг хэлэлцэх хуралдаанд биечлэн оролцоно.

4.2.5.Эрсдэлийн удирдлагын хорооны ажиллах журмын 3.7-д заасан дүгнэлтийг үндэслэн татварын ногдолд залруулга хийж, татварыг нөхөн ногдуулахдаа “Татварын хяналт шалгалтын үйл ажиллагааны журам”-ыг баримтална.

4.3.Татвараас зайлсхийх үйлдлийг бусад этгээдтэй хамтран хэрэгжүүлсэн бол хамтарсан этгээдийн татварын ногдлыг энэ журмын 4.1-д зааснаар уг этгээдийн харьяалах татварын алба хэрэгжүүлнэ.

4.4.Татвараас зайлсхийх үйлдлийг гадаад улсын этгээдтэй хамтран хэрэгжүүлсэн тохиолдолд тухайн ажил гүйлгээний мэдээллийг Татварын ерөнхий хуулийн 18 дугаар зүйлд заасны дагуу харилцан солилцоно.